

Батлав. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тухайн асуудал хариуцсан газрын дарга \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

эсхүл (Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан газрын дарга \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

Монос Хүнс ХК-ийн гүйцэтгэх захирал \_\_\_\_\_ /А. Отгондарь/

**УЛААНБААТАР ХОТ, БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р  
ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “МОНОС  
ХҮНС” ХК-ЫН “ШИНГЭН ХҮНСНИЙ ҮЙЛДВЭР”  
ТӨСӨЛ 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГЕСТРИЙН ДУГААР: 5568927/

Хянасан: Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тухайн асуудал хариуцсан газрын мэргэжилтэн \_\_\_\_\_

эсхүл (Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан газрын тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн) \_\_\_\_\_

Боловсруулсан: Монос Хүнс ХК-ийн Бизнес хөгжлийн албаны Төслийн менежер \_\_\_\_\_  
Б. Оюунжаргал

Хянасан: Монос Хүнс ХК-ийн Бизнес хөгжлийн албаны дарга \_\_\_\_\_ Б. Хаш-Эрдэнэ

АГУУЛГА:

1. Монос Хүнс ХК-ийн Шингэн хүнсний үйлдвэрийн товч танилцуулга
2. Монос Хүнс ХК-ийн Шингэн хүнсний үйлдвэрийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт
3. Монос Хүнс ХК-ийн Шингэн хүнсний үйлдвэрийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч танилцуулга
4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт
  - 4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
  - 4.2 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө
  - 4.3 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
  - 4.4 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
  - 4.5 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө
  - 4.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
  - 4.7 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө
  - 4.8 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө
  - 4.9 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал
5. Хавсралт материалууд

## 1. МОНОС ХҮНС ХК-ИЙН ШИНГЭН ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### ТОВЧ МЭДЭЭЛЭЛ:


**Төслийн нэр:** “Шингэн хүнсний үйлдвэр”

**Төсөл хэрэгжүүлэгч:** “Монос Хүнс” ХК

- Улсын бүртгэлийн дугаар: 9010002005
- Регистрийн дугаар: 5568927
- Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Сонсголонгийн зам гудамж 32/2, Баянгол дүүрэг, Улаанбаатар 16103
- Холбоо барих утас: +976-7777 3525, +976-90108007
- E-mail: [info@monosfood.mn](mailto:info@monosfood.mn), Web: [www.monosfood.mn](http://www.monosfood.mn)

**Төслийн байршил:** “Монос Хүнс” ХК-ийн Шингэн хүнсний үйлдвэр нь Улаанбаатар хотын үйлдвэржилтийн баруун бүс болох Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэр, Сонсголонгийн замын зүүн талд “Монос фарм” ХХК-ийн 33966 м<sup>2</sup> талбай бүхий газарт байрлах 2 давхар үйлдвэр, агуулахын зориулалттай 1800 м<sup>2</sup> талбайтай өөрийн байранд үйл ажиллагаа явуулж байна.

Тус үйлдвэр байрлах газар нь Монос Хүнс ХК-ийн эзэмшил бөгөөд дэргэд нь Монос группын харьяаны Монос Фарм ХХК-ийн Эмийн үйлдвэр, Монос Косметик ХХК-ийн Гоо сайхны үйлдвэр, мөн “Монос Хүнс” ХК-ийн Шингэн хүнсний үйлдвэр тус тус байрлана. Эзэмшил газраас гадагш буюу эргэн тойрон автозам, бусад аж ахуй нэгжийн үйлдвэрлэл, үйлчилгээ, ДЦС-4 зэрэг байрлана.



Зураг 1. Монос группын үйлдвэрийн цогцолбор

Үйлдвэрийн барилга нь 2 давхар бөгөөд 1800 м<sup>2</sup> талбайтай, 1 давхарт үйлдвэрлэл, агуулахын хэсэг, 2 давхарт захиргаа, чанар хяналтын хэсэг байрлана.

Төслийн хүчин чадал, технологи:

Хүснэгт 1. Хүчин чадал

№	Төхөөрөмжийн нэр	Хүчин чадал
1.	Ус цэвэршүүлэх систем	5000 л/ц
Найрлагын систем		
2.	Пэт савтай бүтээгдэхүүний найрлагын шугам	3000л/ц
3.	Уутан болон хуруу шилэн савлагаатай бүтээгдэхүүний найрлагын шугам	2000л/ц
Савлагааны систем		
4.	Пэт халуун савлагааны шугам (500мл багтаамжтай савлагаа)	3000 сав/ц
5.	Пэт хүйтэн савлагааны шугам (500мл багтаамжтай савлагаа)	6000 сав/ц
6.	Уутан савлагааны төхөөрөмж (100мл багтаамжтай уутан савлагаа)	4500 уут/ц
7.	Хуруу шилэн савлагааны төхөөрөмж (20мл багтаамжтай хуруу шилэн савлагаа)	3000 шил/ц
8.	Ургамал хандлах систем	1000 л/өдөрт

**Бүтээгдэхүүний нэр төрөл:** Шингэн хүнсний үйлдвэр нь 3 төрлийн найрлага бүхий 0.33-1.0 л-ээр савлагдсан “Экос” цэвэр ус, 2 төрлийн жимсний ундаа, 6 нэр төрлийн “Цэнэг” эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн, “Vitos-shot” 2 төрлийн биологийн идэвхт бүтээгдэхүүн зэрэг шингэн хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна.

1. Экос ус зөөлөн ус 0.33 л, 0.5 л, 1 л



2. Экос оргилуун хийжүүлсэн ус 0.5 л, 1л

3. Жимсний ундаа - 2 төрөл /Аньс луувантай/



гүзээлзгэнэтэй, чацаргана

4. 20 мл хуруу шилэн савлагаатай

бүтээгдэхүүн

5. Цэнэг брэндийн нэр төрөл - 6 төрөл



**Тоног төхөөрөмж:** Тус үйлдвэр бүтээгдэхүүний савалгаа бэлдэх, үлээх төхөөрөмж, 0.33-1.0 л хэмжээтэй бүтээгдэхүүн савлах шугам, найрлага бэлдэх үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглаж байна.



Зураг 2. Үйлдвэрийн дотоод орчин, тоног төхөөрөмж

**Бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндсэн болон туслах түүхий эд:** Үйлдвэрлэлд нийт 28 нэрийн үндсэн болон туслах түүхий эд, 4 нэрийн ургамал, 2 нэрийн жимс, 58 нэрийн хайрцаг, сав баглаа боодол хэрэглэдэг. Түүхий эд, сав баглаа боодлыг дотоод болон гадаадын /Солонгос, Хятад, ОХУ/ гэрээт бэлтгэн нийлүүлэгчээс авдаг. Ургамлын түүхий эдийг гэрээт бэлтгэн нийлүүлэгч болон

Монос группын харьяаны эмийн ургамлын ботаник хүрээлэнд тарималжуулан ашигладаг. Хайрцаг, сав баглаа боодлын 19 төрөл нь блистер хаяг, пакетлагч, ороогч, 12 нэрийн бэлдэц, бөглөө, 26 нэрийн хайрцаг хэрэглэж байна. Үйлдвэрийн шугам хоолой, тоног төхөөрөмжийн угаалга, цэвэрлэгээнд 8 төрлийн химийн бодисоос жилд 9.4 тн орчмыг ашиглаж байна. Үйлдвэрийн шугам хоолой, тоног төхөөрөмжийн угаалга, цэвэрлэгээний зориулалттай химийн бодисуудыг дотоодын ханган нийлүүлэгч тусгай зөвшөөрөлтэй Жи Эф Ай ХХК-иас худалдан авдаг.

*Дотоод хяналтын лаборатори:* Үйлдвэрийн бүтээгдэхүүн, түүхий эд болон сав баглаа боодлын чанар, аюулгүй байдал, эрүүл ахуйд байнгын хяналт тавьдаг чанарын дотоод хяналтын лаборатори ажилладаг. Лабораторийн үйл ажиллагаа нь хими, микробиологийн 2 салбар нэгжтэй. Чанарын хяналтын лабораторид үйлдвэрлэлийн эхлэл материал болох түүхий эд, сав баглаа боодлоос эцсийн бэлэн бүтээгдэхүүн гарах хүртэлх бүх шат дамжлагад хими болон микробиологийн дэлгэрэнгүй шинжилгээ хийж байна.

*Хүснэгт 2. Шинжилгээ хийх үзүүлэлт*

№	Дээжийн нэр	Химийн шинжилгээ	Микробиологийн шинжилгээ
1	Төвлөрсөн болон цэвэршүүлсэн ус	7-10 үзүүлэлт Хатуулаг, рН, кальцийн хатуулаг, магнийн хатуулаг, шүлтлэг, ЦДЧ, нитрат, нитрит, хлор, хуурай үлдэгдэл	<ul style="list-style-type: none"> <li>▪ Бактерийн ерөнхий тоо</li> <li>▪ <i>E.coli</i></li> <li>▪ <i>Salmonelle spp</i></li> <li>▪ ГБЭТ</li> </ul>
2	Шугамын зайлдас усанд	4-5 үзүүлэлт /хүчил, шүлтийн үлдэгдэл, рН, хлор	<ul style="list-style-type: none"> <li>▪ Бактерийн ерөнхий тоо</li> <li>▪ <i>E.coli</i></li> <li>▪ <i>Salmonelle spp</i></li> <li>▪ ГБЭТ</li> </ul>
3	Савласан усанд	Химийн 10 үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> <li>▪ Бичил биетний ерөнхий тоо</li> <li>▪ <i>E.Coli</i>,</li> <li>▪ <i>Salmonella spp</i></li> </ul>
4	Ундаа, шүүсэнд	Химийн 5 үзүүлэлт	Микробиологийн 5 үзүүлэлт
5	ТЭ	Химийн 3-5 үзүүлэлт	Микробиологийн 5-7 үзүүлэлт
6	СББ	Химийн 3-5 үзүүлэлт	Микробиологийн 5-7 үзүүлэлт

Дотоод хяналтын лабораторит нийт 67 нэр төрлийн химийн бодис, урвалжийг дотоодын ханган нийлүүлэгч тусгай зөвшөөрөлтэй “Грийн химистри” ХХК-иас худалдан авч, ашиглаж байна. Хэмжээний хувьд жилд 35.5 л шингэн бодис, 25.7 кг хуурай, хатуу төлөв байдалтай урвалж, бодис ашиглаж байна.



*Зураг 3. Дотоод хяналтын лаборатори*

Урвалж, бодисыг лабораторитой залгаа тусдаа өрөөнд, зориулалтын тусгай шүүгээнд хадгалдаг.

*Бэлэн бүтээгдэхүүний агуулах:* Үйлдвэрлэлээс гарсан бүтээгдэхүүнийг хүлээн авах, түгээх зориулалттай, үйлдвэрийн барилгын зүүн урд талын 1, 2-р давхарыг бүхэлд нь хамарсан 800 м<sup>2</sup> талбай бүхий GMP стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн хадгалах агуулахтай.

### ДЭД БҮТЭЦ

*Цахилгаан хангамж:* Улаанбаатар хотын цахилгаан түгээх төвлөрсөн сүлжээнд холбогдсон. Монос группын үйлдвэрийн цогцолбор байрлах 33966 м<sup>2</sup> талбай бүхий газрын эзэмшигч Монос фарм ХХК бөгөөд “Цахилгаан эрчим хүчээр хангах, хэрэглэх гэрээ”-г “ДЦС-4” ТӨХК-тай байгуулан ажилладаг.

*Дулаан хангамж:* Үйлдвэрийн барилга байгууламж нь бүхэлдээ Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон.

*Ус хангамж:* Тус үйлдвэр нь Улаанбаатар хотын цэвэр усан хангамжийн төвлөрсөн сүлжээнд холбогдсон. Газар эзэмшигч Монос фарм ХХК “Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ”-г УСУГ-тай байгуулж ажилладаг.

Ус цэвэршүүлэх төхөөрөмжийн суурилагдсан хүчин чадал 5000 л/цаг. Ус цэвэршүүлэх төхөөрөмжөөс гарах хатуулаг ихтэй хаягдал усыг 10 тн багтаамжтай нөөцийн саванд хуримтлуулж, угаалтаас гарах хаягдал усны шингэрүүлэлт, ажлын байрны цэвэрлэгээ, үйлчилгээнд ахуйн зориулалтаар дахин ашиглаж байна.

#### *Хүснэгт 3. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ*

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Хоногт үйлвэрлэгдэх хэмжээ, л	Хоногт үйлвэрлэгдэх хэмжээ м <sup>3</sup>	тайлбар
1.	Савласан ус	6000	6	-
2.	Жүүс	шот: 158.4 халуун пет: 4500 пауч: 1764	6.422	Жүүс бэлтгэх бэлдмэлийн хэсэгт 80% ус байна.

#### *Хүснэгт 4. Нийт ус хэрэглээ*

Д/д	Төрөл	Ашиглах усны хэмжээ		Ажиллах хоног	Жилд, м <sup>3</sup>
		л/хон	м <sup>3</sup> /хон		
1.	Тенхологийн хэрэгцээ	32510	32.51	269	9014.19
2.	Техникийн хэрэгцээ	2951.7	2.9517		794.0
3.	Ажилчдын унд-ахуйн ус хэрэглээ	2160	2.16		581.04
<b>Нийт</b>		<b>37621.7</b>	<b>37.6217</b>		<b>10389.23</b>

*Ариутгах татуурга:* Үйлдвэрийн барилгаас гарах хаягдал ус нь мөн УСУГ-тай байгуулсан “Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ”-ний дагуу төвлөрсөн

сүлжээнд нийлүүлэгддэг. Үүнд ажилчдын ахуйн хэрэглээ, ажлын байрны цэвэрлэгээ болон тоног төхөөрөмжийн угаалга цэвэрлэгээний хаягдал ус бүгд хамаарна.

### ХОГ ХАЯГДАЛ

*Ахуйн хаягдал:* Ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах хатуу хог хаягдлыг түр цэгт хуримтлуулан, Баянгол дүүргийн тохижилт үйлчилгээ хариуцсан “Баянгол шинэ өргөө” ОНӨААТҮГ-тай байгуулсан гэрээний дагуу тээвэрлэгч байгууллагад нийлүүлж байна. Хог хаягдал зайлуулах үйлчилгээний хураамжийн хэмжээг Баянгол дүүргийн ИТХ-ын 7/04 тоот тогтоолд заасан тарифаар тооцон, үйлчилгээний хөлсийг төлдөг.

*Химийн бодисын сав баглаа боодол:* Тоног төхөөрөмжийн ариутгал цэвэрлэгээнд ашиглаж буй химийн бодисын сав баглаа боодлын хаягдлыг одоогоор өөрийн үйлдвэрт тусгай агуулахад бүртгэлжүүлэн хадгалдаг. Химийн бодисын сав баглаа боодол нь 20, 23, 25, 30 болон 250 кг-ийн багтаамжтай хуванцар савнууд байна. Химийн бодисын сав баглаа боодлыг нийлүүлэгч Жи Эф Ай ХХК-тай байгуулсан худалдах-худалдах авах гэрээнд зааснаар импортлогч байгууллагад буцаан нийлүүлнэ.

*Микробиологийн хаягдал:* Дотоод хяналтын лабораториос гарах био хаягдлыг “Элемент медикал” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 14 хоногт 1 удаа устгуулдаг. Хаягдал хуримтлуулах зориулалтын “био хаягдал” бүхий тэмдэглээтэй, шар өнгийн, автоклавын температурт тэсвэртэй уутыг Монбиофарм ХХК-иас худалдан авч ашигладаг.

## 2. МОНОС ХҮНС ХК-ИЙН ШИНГЭН ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

**Төсөл хэрэгжиж буй талбайн физик газарзүй:** “Монос Хүнс” ХК-ийн Шингэн хүнсний үйлдвэр нь Улаанбаатар хотын үйлдвэржилтийн баруун бүс болох Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлана. Тухайн нутаг дэвсгэрт хүн ам суурьшаад олон жил болсон барилга байгууламж үйлдвэрлэл зам харилцаа эрчимтэй хөгжсөн тул газрын гадаргын унаган төрх байдал бүрэн өөрчлөгдсөн. Ашиглаж буй 3.4 га талбайн 70 хүртэлх хувьд 1-2 давхар захиргаа, үйлдвэр, агуулахын барилга, хатуу хучилттай зам талбай хийгдсэнээс гадна бусад сул хэсгийг ногоон байгууламж болгон тохижуулж, орчны өнгө үзэмжийг сайжруулсан, газрыг зориулалтын дагуу ашиглаж байна. Ашиглаж буй газрын гадаргын үндсэн төрх байдал, физик газарзүйн нөхцөл хүний үйл ажиллагаа, хотжилтын нөлөөгөөр бүрэн өөрчлөгдсөн.

**Уур амьсгал:** Үйлдвэрийн үйл ажиллагаанаас уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх сөрөг нөлөөлөл байхгүй.

**Агаарын чанар:** Үйлдвэрийн үйл ажиллагаанд агаар бохирдуулах суурин эх үүсвэр ашигладаггүй, УБ хотын цахилгаан, дулааны төвлөрсөн системд холбогдсон. Харин үйлдвэрийн шугам сүлжээний ариутгал цэвэрлэгээнд ашигладаг химийн хорт болон аюултай бодисын хадгалалт, ашиглалтын үед ажилчдын санамсар болгоомжгүй байдлаас их хэмжээний асгаралт үүсч, агаарт ууршиж болзошгүй.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний ажлын хүрээнд үйлдвэрийн дотоод буюу ажлын байрны орчин, гадаад орчноос агаар бохирдуулагч хий, тоосны агууламжийг 20 минутын дундаж үзүүлэлтээр 2020 оны 03 сард БОХЗТЛ-иос хийсэн ба гадаад орчны агаарын чанарын үзүүлэлт “MNS 4585:2016 агаарын чанар, техникийн шаардлага” стандартын хүлцэх агууламжаас нийт тоос 5 дахин (0.102 мг/кг), азотын давхар исэл 7 дахин (0.028 мг/кг), хүхэрлэг хий 30 дахин (0.015 мг/кг) бага, харин ажлын байрны дотоод орчны агаарын чанар “MNS 4990:2015 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн

шаардлага” стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс нийт тоосны агууламж 23 дахин (0.086 мг/кг), азотын давхар ислийн агууламж 86 дахин (0.023 мг/кг) бага буюу маш бага илэрцтэй байсан.

**Гадаргын ус:** Үйлдвэр байрлах талбай нь Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20-р хорооны нутагт байрлана. Хотын нутаг дэвсгэр Туул голын сав газарт хамаарагддаг. Төслийн талбайгаас Туул гол хүртэл 1 орчим км зайтай тул гадаргын усанд үзүүлэх нөлөөлөл байхгүй.

**Газрын доорх ус:** Үйлдвэр нь техник, технологийн болон ажилчдын ахуйн хэрэглээний усыг Улаанбаатар хотын төвийн шугам сүлжээнээс авч ашигладаг. Улаанбаатар хотын УСУГ нь унд-ахуй болон үйлдвэрлэлийн хэрэгцээнд газрын доорх усыг олборлон төвлөрсөн болон төвлөрсөн бус шугам сүлжээгээр дамжуулан хэрэглэгчдэд түгээдэг. Улаанбаатар хотын төвлөрсөн ус хангамжийн газрын доорх усны 4 үндсэн (Төвийн, Дээд, Үйлдвэрийн, Мах комбинатын) эх үүсвэр, ТЭЦ-3, ТЭЦ-4 гэсэн нэртэй нийтдээ 218 цооногоос бүрдсэн төвлөрсөн эх үүсвэрүүдтэй. “Монос Хүнс” ХК-ийн “Шингэн хүнсний үйлдвэр” нь Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах тул төвлөрсөн ус хангамжийн “Мах комбинатын эх үүсвэр”-ээс цэвэр усаар хангагдаж байна. Доржсүрэн.Д., Пүрэвхүү.Д., Ганчимэг.О нарын хамтарсан “Улаанбаатар хотын төвлөрсөн ба төвлөрсөн бус ус хангамжид ашиглагдаж байгаа газрын доорх усны нөөцийг дахин үнэлж, ашиглалтын зохистой горимыг тогтоох ажлын гол үр дүн” илтгэлд дурьдсанаар төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрүүдийн газрын доорх усны нөөцийн дахин үнэлгээний дүнгээр “Мах комбинатын эх үүсвэр”-ийн нөөц нь 8018.6 м<sup>3</sup>/хоног (С зэргээр) гэж тооцсон. Үйлдвэр нь төвлөрсөн сүлжээний усыг цэвэршүүлэн, шингэн хүнс үйлдэрлэдэг. Ус цэвэршүүлэх системийн суурилагдсан хүчин чадал 5000 л/цаг. Иймд газрын доорх усны нөөцөд шууд сөрөг нөлөөлөл үзүүлж байна.

**Газрын гадарга, хөрсөн бүрхэвч:** Үйлдвэр байрлаж буй талбай нь Баянгол дүүргийн 20-р хороо бөгөөд тус район нь Улаанбаатар хотын үйлдвэрийн бүсэд хамаарна. Зөвшөөрлөөр олгогдсон нийт талбайн хэмжээ 33966 м<sup>2</sup> бөгөөд үүний 60-70% нь барилга байгууламж, хатуу хучилттай зам талбай эзэлнэ.

Тус үйлдвэр байрлах газар нь Монос фарм ХХК-ийн эзэмшил бөгөөд Монос группын харьяаны Монос фарм ХХК-ийн Эмийн үйлдвэр, Моноскометик ХХК-ийн Гоо сайхны үйлдвэр, мөн “Монос Хүнс” ХК-ийн Шингэн хүнсний үйлдвэр тус тус байрлана.

2020 онд хийгдсэн хөрсний судалгаагаар шаврын эзлэх хувь ялзмаг хуримтлалын А үе давхаргадаа 14,0 буюу *элсэнцэр механик* бүрэлдэхүүнтэй хөрс байна. Том болон жижиг ширхэгтэй элс 68,1%, том ширхэгтэй тоос 17,8%, дунд ширхэгтэй тоос 4,6%, нарийн тоос 5,1%-ийг тус тус эзлэж байна. Лаг шаврын эзлэх хэмжээ бага буюу 4,3% гарсан байна. Элсэнцэр буюу хөнгөн хөрс нь агаар болон усны нэвчүүлэх чадвар сайтай байдаг ч ус барих чадвар муутай байдаг онцлогтой. Мөн байгалийн үржил шимээр тааруу, салхины үлээлтэнд хялбар өртөх эрсдэлтэй байдаг. Хөрсний агрохимийн үзвэл тухайн хөрс нь дунд шүтлэг урвалын орчинтой байна. Хөрсний ялзмагийн агууламж А үедээ 1,13 байна. Хөрс давсжилтгүй, хөрсний үржил шимийн гол үзүүлэлтүүдийн нэг болох хөдөлгөөнт фосфор (хөрсөн дэх фосфор нь өсөлт хөгжилтийн эхний үе шатуудад залуу ургамлын өсөлт хөгжилт үндэсний нэвтрэх чадварт фосфор чухал нөлөөтэй) 1 буюу маш муу, калийн (Кали нь ургамлын бодисын солилцоонд зонхилох үүргийг гүйцэтгэдэг) агууламж 11 буюу тааруу байна. Хөрсний шингээгдсэн сууриуд болох Са-11.0, Mg-2.3, нийтдээ 13,3 буюу их үзүүлэлттэй байна. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин *дундаж* үзүүлэлттэй гарч байна. Хөрсний өнгөн хэсгээс дээж авч, Зэс /Cu/ 19.2 мг/кг, Цайр /Zn/ 75.2 мг/кг, Никель /Ni/ 34.2 мг/кг, Хром /Cr/ 16.8 мг/кг буюу бохирдолгүй, мөн Кадми /Cd/ тодорхойлж, “MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандартын хүлцэх агууламжтай харьцуулахад бохирдол



илрээгүй байна. Харин хартугалга /Pb/-ын агууламж 61.1 мг/кг буюу стандартын хүлцэх агууламжаас 1.1 мг/кг-аар хэтэрсэн үзүүлэлттэй буюу бохирдсон байна. Цаашид анхаарал хандуулах болно.

**Ургамлан нөмрөг:** Үйлдвэрийн ашиглаж буй талбайн 80 хүртэлх хувьд нь барилга байгууламж, хатуу хучилттай зам талбай баригдсан, 500 м<sup>2</sup> талбайд ногоон байгууламж байгуулсан.

Монос группын харьяа Моносфарм ХХК, Моноскосметик ХХК болон Монос Хүнс ХК-иуд нь 1 газар төвлөрч үйл ажиллагаа явуулдаг ба Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.6-д Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана” гэж заасны дагуу байгууллагын хашаандаа үхрийн нүд, шар хуайс, зарим зүйлийн бургас зэргийг тарьж агаарын бохирдлыг бууруулах болон орчны өнгө үзэмжинд эерэг нөлөө үзүүлж байна.

**Амьтны аймаг:** Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн суурьшлын бүс нь бүхэлдээ барилга байгууламж, хотжилтын нөлөөнд өртсөн. Улаанбаатар хот орчмын газар нутаг нь Монгол орны хөхтөн амьтдын газарзүйн мужлал (Банников, 1954)–аар Хойт доод муж, тайгын провинци, Хэнтийн тойрогт, харин Монгол орны шувуудын газарзүйн тархацын хуваарилалтаар Улаанбаатар, түүний орчмын нутаг нь Европ-Азийн шилмүүст ойн дэд мужийн Хэнтийн провинц ба Европ-Азийн хээрийн дэд мужийн Монгол-Дагуурын хээрийн провинцид багтах Хэнтий, Монгол Дагуурын хээрийн тойргуудад хамаарна. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймгийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөлөл байхгүй.

**Тусгай хамгаалалттай газар нутаг:** Үйлдвэр байрлаж буй талбай нь Тусгай Хамгаалалттай Газар Нутагт харьяалагдахгүй тул түүнд үзүүлэх нөлөөлөл байхгүй.

**Түүх соёлын өв:** Шингэн хүнсний үйлдвэрийн үйл ажиллагаанаас дээрх түүх соёлын дурсгалуудад сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй болно.

**Нийгэм-эдийн засаг:** Монос Хүнс ХК-ийн Шингэн хүнсний үйлдвэр нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн харьяаллаар Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт хамаарагдана. Үйлдвэр байрлах газар нь Монос фарм ХХК-ийн эзэмшлийн талбай юм. Энд Монос группын харьяаны Монос фарм ХХК-ийн Эмийн үйлдвэр, Моноскосметик ХХК-ийн Гоо сайхны үйлдвэр, мөн Монос Хүнс ХК-ийн Шингэн хүнсний үйлдвэр тус тус байрлана. Эдгээр үйлдвэрүүд эргэн тойрондоо хавсарсан нөлөөллийг үзүүлнэ. Эзэмшил газраас гадагш буюу эргэн тойрон автозам, бусад аж ахуй нэгжийн үйлдвэрлэл, үйлчилгээ, ДЦС-4 зэрэг байрлана. Харин гэр хорооллын болон орон сууцны айл өрхөөс зайтай. Баянгол дүүргийн 20-р хороо нь нийслэлийн үйлдвэржилтийн баруун бүс бөгөөд үйлдвэр, үйлчилгээний олон байгууллага, ахуй нэгжүүд байрладаг.

Монос Хүнс ХК нь Монос группын салбар компани бөгөөд хүнс болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр 2011 оноос үйл ажиллагаа явуулж байгаа үндэсний үйлдвэрлэгч компани юм.

### 3. МОНОС ХҮНС ХК-ИЙН ШИНГЭН ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТӨВЧ ТАНИЛЦУУЛГА

Монос хүнс ХК-ийн Баянгол дүүргийн 20-р хороонд байрлах шингэн хүнсний үйлдвэрийн үйл ажиллагааны үед байгаль орчны бүрдэл хэсэг, хүний эрүүл мэнд, нийгэм-эдийн засгийн хөгжилд үзүүлж болох нөлөөллийн үнэлгээг магадлан жагсаах аргаар гүйцэтгэлээ.

*Хүснэгт 5. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн төвч тодорхойлолт*

№	Байгаль орчны үзүүлэлтүүд	Нөлөөлөл		Хугацаа		Давталт			Эрчим		
		Шууд	Шууд бус	Богино хугацааны	урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	өөрөө зохицуулагдах	Бага зэрэг	Дунд зэрэг	Хүчтэй
<b>1. Биологийн төрөл зүйлийн оршин амьдрах нөхцөл</b>											
1.	Газрын доорх усны урсацын өөрчлөлт	X			X		X				X
2.	Хөрсний эвдрэл		X	X			X		X		
<b>2. Байгалийн нөөц, ашиглалт</b>											
1.	Эрчим хүчний нөөц		X		X		X			X	
<b>3. Байгаль орчны өөрчлөлт</b>											
1.	Газрын доорх усны чанарын өөрчлөлт		X	X		X			X		
2.	Агаарын бохирдол	X						X			
3.	Хөрсний бохирдол	X			X	X				X	
4.	Дуу чимээний нөлөө	X			X	X			X		
<b>4. Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөл</b>											
1.	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	X			X		X			X	
2.	Хүн амын орлого өөрчлөгдөх	X			X		X		X		
<b>5. Эдийн засаг, байгаль орчин</b>											
1.	Төсвийн орлого нэмэгдэх	X			X		X			X	
2.	Ажлын байр нэмэгдэх	X			X		X		X		
3.	Ядуурлыг бууруулах дэмжлэг болох	X			X		X		X		
<b>6. Бусад нөлөөлөл</b>											
1.	Ажлын байрны агаарын чанар, хөдөлмөрийн нөхцөл ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх	X			X		X			X	
2.	Үйлдвэрлэлийн гаралтай хог хаягдлын хуримтлал үүсэх	X		X		X				X	
3.	Бохирдол ихтэй үйлдвэрийн хаягдал ус ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэгдэх	X			X		X			X	

“Монос хүнс” ХК-ийн шингэн хүнсний үйлдвэрийн үйл ажиллагаа нь ажлын байр нэмэгдүүлэх, хүн амын амьжиргаа дээшлэхэд нөлөөлөх, үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих зэрэг үзүүлэлтүүд тодорхой хэмжээнд эерэг нөлөө үзүүлнэ. Харин хүний эрүүл мэндэд үзүүлэх шууд сөрөг нөлөөлөл гарахгүй бөгөөд ажиллагсадын өөрсдийн хайхрамжгүй байдлаас үүдэлтэй сөрөг нөлөөлөл гарч болзошгүй. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх хамгийн гол сөрөг нөлөөлөл нь цэвэр усны нөөцийн ашиглалт, үйлдвэрлэлийн гаралтай хатуу, шингэн хог хаягдлаас үүсэх сөрөг нөлөөлөл байна. Үйлдвэр байрлах газар нь хүн ам суурьшаад олон жил болсон барилга байгууламж үйлдвэрлэл зам харилцаа эрчимтэй хөгжсөн тул газрын гадарга,

хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгийг унаган төрх байдал бүрэн өөрчлөгдсөн байна. Өөрөөр хэлбэл шууд эрчимтэй сөрөг нөлөөлөл үзүүлсэн байна.

#### 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараах зорилтуудыг тавьсан болно. Үүнд:

- ✓ Байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулахад анхаарал хандуулах
- ✓ Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нийцлийг хангах
- ✓ Эх үүсвэр дээрх хог хаягдлын хэмжээг бууруулах, эх үүсвэр дээр нь ангилан ялгах, дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх
- ✓ Үйлдвэрийн хаягдал бохир усны чанарт хяналт тавьж, стандартын шаардлага хангасан хаягдал усыг ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх
- ✓ Байгалийн нөөц ашигласны төлбөрийг төлөх

#### 4.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
<b>ХӨРС</b>									
1	Хог хаягдлын хуримтлал үүсч, орчны бохирдлыг нэмэгдүүлэх	Энгийн хог хаягдлыг зайлуулах гэрээг шинэчлэн байгуулж, хог хаягдлаа тогтмол хугацаанд тээвэрлэгчид нийлүүлж байх	Хог хаягдал	тн	15.6	-	-	Тогтмол 7 хоногт 1 удаа	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.3, 10.2.4, 10.2.7
2	Хог хаягдлыг удаан хугацаанд хуримтлуулснаар таагүй үнэр орчинд тархах	Ариутгал халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх /ажлын байр, хог хаягдлын цэг, бохир ус дамжуулах худаг, ногоон байгууламж/	Хог хаягдлын цэг	м2	61,2	5000	309,000	Дулааны улиралд сард нэг удаа, хүйтний улиралд хоёр сард нэг удаа угааж, ариутгал халдваргүйжүүлэлтийг хийх;	“Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ын 7.7.10 <sup>1</sup>
3	Ашиглаж буй газрын сул талбайн хөрс бохирдох	Хөрсний төлөв байдал, чанарын хяналтыг тогтмол хэрэгжүүлэх	Хөрсний төлөв байдал	-	-	2-3	235,000	Жилд 2 удаа	MNS 5850:2019 MNS 3297:2019
<b>АГААР ХАМГААЛАХ</b>									
4	Ажлын байрны Агаарын бохирдох	Орчны агаарын чанарын хэмжилтийг хийлгэж, дүгнэлт гаргуулж байх	Гадаад, дотоод орчин	Мг/м3	-	-	ОХШХ-д туссан	Улиралд 1 удаа	Агаарын тухай хуулийн 9.1.4, MNS 4585:2016 MNS 4990:2015

<sup>1</sup> 2023 оны ҮА зардалд тусгав.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
5	Агааржуулалтын систем доголдох, эвдрэл гарах, ажлын байрны орчин нөхцөл алдагдах	Үйлдвэрийн барилгын ерөнхий болон зарим хэсэгчилсэн агааржуулалтын системийн хэвийн ажиллагаанд хяналт тавих, үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Агааржуулалтын систем	-	-	-	204,000	Жилд 2 удаа	“Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”-ын 3.5.17 <sup>2</sup>
6	Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс ялгарах хорт хий нь гадаад орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлөх	Компанийн эзэмшлийн тээврийн хэрэгслүүдийг үзлэг оношилгоонд хамруулна	Түгээлт, тээвэрлэлтийн бүх тээврийн хэрэгсэл	ш	-	-	ҮА-ны зардал	Жилд 1 удаа	“Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын Үзлэг явуулах журам” <sup>3</sup>
<b>УСНЫ НӨӨЦ, ЧАНАР</b>									
7		Хэрэглээний цэвэр, бохир усны төлбөрийг тоолуурын дагуу тогтмол төлөх	Төвлөрсөн шугамын ус	м <sup>3</sup>	-	-	ҮА-ны зардал	Сар бүр	Улаанбаатар хотын цэвэр, бохир усны үйлчилгээний тариф батлах тухай журам <sup>4</sup>
8	Усны нөөцийн хомсдол	Цэвэршүүлэх төхөөрөмжөөс гарах хаягдал усыг дахин ашиглах /өрөө тасалгааны цэвэрлэгээ, тоног төхөөрөмжийн ариутгал цэвэрлэгээний	Хатуулаг ихтэй ус	м <sup>3</sup>	10,2	-	ҮА-ны зардал	Сар бүр	MNS 6734:2018

<sup>2</sup> Монгол улсын Шадар сайд, БОАЖ-ын сайд, ЭМ-ийн сайдын 2017 оны 05 сарын 23 өдрийн 54/А/136/А215 тоот хамтарсан тушаалын хавсралт


<sup>3</sup> Зам тээврийн сайдын 2013 оны 10 сарын 21 өдрийн 232 дугаар тушаалын 1-р хавсралт

<sup>4</sup> Хот суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2019 оны 03 сарын 29 өдрийн 23 дугаар тогтоолын хавсралт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		уусмалын шингэрүүлэлт, ариун цэврийн өрөөний почка г.м/							
9		Байгалийн нөөц ашигласны төлбөр төлөх	Цэвэр ус ашиглалт	м3			ҮА-ны зардал	Сар бүр	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 6.1.1
10	Гэрээний үүргийн зөрчил үүсэх, зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн ашиглах	Ус ашиглах зөвшөөрлийг холбогдох төр захиргааны байгууллагаас авч, усаар хангагч байгууллагатай хийсэн гэрээний үүргээ биелүүлэн ажиллах	Цэвэр ус ашиглалт	м3	10760	-	ҮА-ны зардал	Сарын 10-ны дотор, жилийн тайланг дараа оны 01 сарын 10-ны дотор харьяалагдах татварын албанд	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль 23.2
11	Бохирдол өндөртэй ус ариутгах	Хаягдал усны чанарын хяналтыг тогтмол хэрэгжүүлэх	Хаягдал ус	л/жил	-	-	ОХШХ-д туссан	Өдөр бүр	MNS 6561:2015
12	татуургын сүлжээнд нийлүүлэгдэх	СIP цэвэрлэгээний хаягдал усыг бүрэн саармагжуулсны дараа ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх	СIP цэвэрлэгээний хаягдал ус	м3/жил	10.2	-	ОХШТ-ны дагуу	Байнга	Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 15.1.1
	<b>Нийт</b>						<b>748,000</b>		

## 4.2 ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 7. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1.	Тоосжилтыг бууруулах, орчны өнгө үзэмжийг сайжруулах	Цаашид өөрийн эзэмшлийн талбай дах ногоон байгууламжийн арчилгаа усалгааг тогтмол хийх	Компанийн эзэмшил талбай дах ногоон байгууламж	м2	600		4,000,000	Дулааны улиралд	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай 7.2.4, Газрын тухай хуулийн 56.6 MNS 6260:2011
3	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд	Мод тарих тоо/ш	MFC нэг ажилтан нэг мод хөтөлбөр хэрэгжүүлэх	ш	300	50,000	15,000,000	Хаврын улиралд	
<b>Нийт</b>							<b>19,000,000</b>		

## 4.3 ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйлдвэрийн үйл ажиллагаанаас түүх соёлын үнэт өв, олдворт үзүүлэх нөлөөлөл байхгүй тул түүх, арга хэмжээг төлөвлөх шаардлагагүй.

#### 4.4 ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал, эрүүл мэндийн аюулгүй байдал алдагдах	Ажилчдад хөдөлмөрийн аюулгүй байдлын журмууд, хөдөлмөр хамгааллын заавар, осол аваар гарах үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дотоод сургалтыг тогтмол зохион байгуулах	ХАБЭА	Бүх ажилчид	ХАБЭА-н үйл ажиллагааны зардалд тусгасан		Жилд 2 удаа	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, MNS 4969:2000 стандарт, ХНХЯ-ны сайдын А/367 тоот тушаалын хавсралт журам
2	Аюулгүй байдал, эрүүл мэндийн шаардлага зөрчигдөх	Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж буй ажиллагсадыг эмнэлгийн үзлэгт хамруулах	ХАБЭА		ХАБЭА-н үйл ажиллагааны зардалд тусгасан		Жилд 2 удаа	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14-р зүйл
3	Онцгой байдал болон галын аюулгүй байдал алдагдах	Галын болон онцгой байдлын хэрэгслийн бэлэн байдлыг хянах, шалгах, цэнэглэх, осол аваар гарсан үед ослын төлөвлөгөөг хэрэгжүүлэх	ХАБЭА, Галын аюулгүй байдал		Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд зардал тусгагдсан		үзлэг-сард 1 удаа	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.2, 17.2.4, 17.2.6, 17.3
4	Агааржуулалтын систем доголдох, эвдрэх	Агааржуулах системийн ажиллах заавар, схем зургийг нүдэнд ил харагдах газар байрлуулах	Барилгын ерөнхий болон хэсэгчилсэн агааржуулалт		ҮА-ны зардалд тусгасан		2024 он	Агаарын тухай хуулийн 9.1.9



№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
5	Дуу чимээ ихээр үүсгэгч тоног төхөөрөмжийн орчимд удаан хугацаагаар ажиллахад сонсголын эрхтэн гэмтэх, мэргэжлээс шалтгаалах өвчлөлд өртөх	Дуу чимээ ихээр үүсгэгч тоног төхөөрөмж дээр ажиллаж буй ажилчдад чихний бөглөө тогтмол олгох	Гол урсгал шугам	25		ХАБЭА-н үйл ажиллагааны зардалд тусгасан	Байнга	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.1 MNS 4990:2015 стандарт
<b>ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ</b>								
6	Химийн бодисын хяналт алдагдах	Химийн бодисын зөвшөөрлийн хугацааг сунгуулах Химийн бодисын ашиглалт, зарцуулалтын бүртгэлийг тогтмол хөтөлж, тайланг холбогдох байгууллагад хүргүүлэх	Химийн бодисын ашиглалт	75 нэр төрөл	-	100,000	Дүүргийн Засаг даргад 11 сарын 15 дотор, БОАЖЯ-нд дараа оны 01 сард багтаан хүргүүлнэ	Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 13.7
7	Хадгалалтын аюулгүй байдлын дүрэм, стандарт зөрчигдөх	Химийн бодисыг стандартын шаардлага хангасан агуулахад хадгална.	Агуулах	-	-	ҮА-ны зардал	Байнга	MNS 6458:2014

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
8	Гэнэтийн асгаралт, орчны бохирдол үүсгэх	Агуулахад асгаралтын иж бүрдэл, ослын үеийн бэлэн байдлыг хангана.	Агуулах	-	-	ҮА-ны зардал	Байнга	Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам <sup>5</sup>
9	Ажилчдын анхаарал болгоомжгүй байдлаас үүдэн их хэмжээний асгаралт үүсэх	Хэрэв химийн бодисын хадгалалт, ашиглалтын үед болзошгүй байдлаар асгарсан тохиолдолд асгаралтын үеийн менежментийг хэрэгжүүлнэ.	Хадгалалт, ашиглалтын үед	-	-	ҮА-ны зардал	Асгаралт болсон үед	“Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”-ын 4.22 <sup>6</sup>
10	Химийн бодисыг зөөх, буулгах явцад санамсаргүй байдлаар асгарах, хөрс, газрын гадаргыг бохирдуулах	Химийн бодисуудыг буулгах, зөөхдөө анхаарал болгоомжтой ажиллаж, зөөврийн хэрэгсэл ашиглах /forklift/	Химийн бодис	-	-	ҮА-ны зардал	Байнга	“Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”-ын 3.5.10 <sup>7</sup>
	<b>Нийт</b>					<b>100,000</b>		

<sup>5</sup> Монгол улсын Шадар сайд, БОАЖ-ын сайд, ЭМ-ийн сайдын 2017 оны 05 сарын 23 өдрийн 54/А/136/А215 тоот хамтарсан тушаалын хавсралт

<sup>6</sup> Монгол улсын Шадар сайд, БОАЖ-ын сайд, ЭМ-ийн сайдын 2017 оны 05 сарын 23 өдрийн 54/А/136/А215 тоот хамтарсан тушаалын хавсралт

<sup>7</sup> Монгол улсын Шадар сайд, БОАЖ-ын сайд, ЭМ-ийн сайдын 2017 оны 05 сарын 23 өдрийн 54/А/136/А215 тоот хамтарсан тушаалын хавсралт

#### 4.5 ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Ахуйн	Хог хаягдал зайлуулах гэрээг дүүргийн тохижилт үйлчилгээ хариуцсан байгууллагатай жил бүр байгуулж, үйлчилгээний хөлсийг тогтмол төлөх	Ахуйн хог хаягдлын хэсэг	-	-	-	Дүүргээс тогтоосон тарифын дагуу	Төлбөрийг сар бүр төлөх	Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.3, 10.2.7
2		Хог хаягдлыг тээвэрлэгчид нийлүүлж, хог хаягдал түр хадгалах цэгт ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэх	Ахуйн хог хаягдлын хэсэг	тн		10-12	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан	Сар бүр тээвэрлэгчид нийлүүлэх, ариутгалыг дулааны улиралд хийлгэх	Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага <sup>8</sup>
3		Энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээрээ бууруулах, ангилан ялгах, дахин боловсруулах үйлдвэр, 2-догч түүхий эд хүлээн авах цэгт өгөх зэргээр санаачлагыг нэвтрүүлж ажиллах	Ахуйн хог хаягдлын хэсэг	-	-	-	203,000	Сард 2 удаа	Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.8, 10.2.16

<sup>8</sup> Монгол улсын Шадар сайд, БОАЖ-ын сайд, ЭМ-ийн сайдын 2017 оны 05 сарын 23 өдрийн 54/А/136/А215 тоот хамтарсан тушаалын хавсралт

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		Органик хаягдлыг био уутанд ялзмагжуулан, бордоо болгох	Хоол хүнсний үлдэгдэл, ногооны хаягдал	кг	-	-	70,000	Байнга	Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.8
		Хог хаягдлын тогтмол бүртгэж, жил бүрийн БОМТ-ний биелэлтэд оруулж, төрийн захиргааны байгуулагад тайлагнаж байх	Ахуйн хог хаяглоог хэсэг	-	-	-	ҮА-ны зардал	Жил бүр	Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.13
		Үйлдвэрийн гадаад орчны эргэн тойрон 50метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас, мөсийг хариуцан цэвэрлэх	Нийтийн эзэмшлийн хог хаягдал	-	-	-	ҮА-ны зардал	Байнга	Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар 10.2.10
4	Үйлдвэрийн	Ус цэвэршүүлэх төхөөрөмжөөс гарах хаягдал усыг хоёрдогч хэрэглээнд дахин ашиглах	Технологийн хаягдал	-	-	-	ҮА-ны зардал	Байнга	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.18
		Хуванцарын бэлдэц, сав, рулон зэргийг ангилан цуглуулж, 2-догч түүхий эд, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Үйлдвэрлэлийн хаягдал	-	-	-	ҮА-ны зардал	Сар бүр	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.18

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
5	Аюултай	Аюултай хог хаягдлын бүртгэлийн дугаар авах	Аюултай хог хаягдал	-	-	-	-	2024 он	Хог хаягдлынтухай хуулийн 21.1
6		Химийн бодисын сав баглаа боодлыг цэвэрлэж, аюулгүй түр хадгалах, бүртгэлжүүлэх	Сав баглаа боодол	ш	-	-	-	Байнга	Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам 6.4, 6.5, 6.6, 6.7, 6.8
7		Одоо үүссэн байгаа химийн бодисын сав баглаа боодлыг бүртгэлжүүлж, химийн бодис нийлүүлэгч талд шилжүүлэх	Сав баглаа боодол	ш	-	170	ҮА-ны зардал	улиралд 1 удаа	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.5, Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт
8		Микробиологийн хаягдлыг ахуйн хог хаягдлаас тусад нь хуримтлуулж, мэргэжлийн байгууллагаар гэрээний дагуу устгуулах, бүртгэл хөтлөх	Микробиологийн лабораторийн хаягдал	кг	-	4-5	403,000	Улиралд 1 удаа	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.5
9		Холимог уусмалын хаягдлыг хүчил-шүлтийн үйлчлэлд тэсвэртэй саванд цуглуулж, бүрэн саармагжуулан, ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх	Хаягдал ус	л/жил	-	50	800,000	Өдөр бүр	MNS 6561:2015
	<b>Нийт</b>						<b>1,476,000</b>		

#### 4.6 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	
<b>АГААРЫН ХЯНАЛТ</b>								
1	- Тоос (TSP) эсвэл PM10, PM2.5 - SO2 - NO2 - Дуу шуугиан	дотоод орчин гадаад орчин	Жилд 3 удаа	2-3		238,000		MNS 4585:2016
<b>АЖЛЫН БАЙРНЫ ОРЧИН</b>								
2	Эргономик хэмжилт • Температур • Чийгшил • Гэрэлтүүлэг	Гол урсгал шугамын хэсэг Ус цэвэршүүлэх хэсэг	Байнга	-	-	Төхөөрөмж суурилуулах зардлыг дотоод үйл ажиллагааны зардалд тусгах		MNS 5885:2008 MNS 4990:2015
<b>ХӨРСНИЙ БОХИРДОЛ</b>								
3	Физик-химийн үзүүлэлт	Ногоон байгууламжийн хэсэг	Жилд 2 удаа	2	-	103,000		MNS 3297:2019
4	Хүнд металлын үзүүлэлт	Ашиглаж буй газрын сул хөрстэй хэсэг <b>Нийт 2-3 хүртэлх цэгт</b>	Жилд 2 удаа	2	-	170,000		MNS 5850:2019
<b>ЦЭВЭР, БОХИР УС</b>								
5	Цэвэр усны микробиологийн үзүүлэлт	Төвлөрсөн сүлжээний ус	Жилд 2 удаа	2	-	138,000		MNS 0900:2018

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
6	Цэвэр усны физик-химийн үзүүлэлт			2		189,000		
7	Бохир усны чанарын үзүүлэлт	CIP цэвэрлэгээний хаягдал ус	Улиралд 1 удаа	4		370,000		MNS 6561:2015
	<b>Нийт</b>					<b>1,208,000</b>		

#### 4.7 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 11. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө*

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2023 он				
			Сар 1	Сар 6	Сар 12		
	1	2	3	4	5	6	7
<b>БАЙГАЛЬ ОРЧНЫ УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО</b>							
1	Жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлж, биелэлтийг тайлагнаж ажиллах	ҮА-ны зардал	Жил бүр төлөвлөгөөг өмнөх оны 12 сарын 31-ны дотор, хэрэгжилтийг 11 сарын 01-ний дотор			Төслийн менежер БХА-ны дарга	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянах батлах, тайлагнах журам <sup>14</sup>
2	Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэж, аудитын тайланг зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх	Гэрээний дагуу	2 жил тутамд			Төслийн менежер БХА-ны дарга	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 <sup>1</sup>
<b>ДОТООД ХЯНАЛТ</b>							
3	Дотоод хяналт шалгалтыг боловсруулж, хэрэгжүүлж ажиллах	ҮА-ны зардал	Жилд 2 удаа			Үйлдвэрийн дарга, Чанарын менежер	Хэрэгжүүлэлтийг байнга

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2023 он				
			Сар 1	Сар 6	Сар 12		
	1	2	3	4	5	6	7
4	Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулж, бууруулж ажиллах	ҮА-ны зардал	Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах			Үйлдвэрийн дарга, Дотоод аудитын баг	Зөрчил илэрсэн үед арилгах арга хэмжээг хэрэгжүүлнэ
<b>ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО</b>							
5	Бүтээгдэхүүний хөндлөнгийн чанарын хяналт шинжилгээг тогтмол хийлгэх	ҮА-ны зардал	Улиралд 1 удаа			Чанарын менежер	Итгэмжлэгдсэн лабораторит
6	Ажилчдыг ариун цэвэр, эрүүл ахуйн сургалтанд хамруулах, эсвэл дотооддоо зохион байгуулах	ҮА-ны зардал	Жилд 2 удаа			Чанарын менежер	Жилд 2 удаа
7	Ажлын байранд ариутгал, халдваргүйтгэлийг хийлгэх	ҮА-ны зардал	Жилд 2 удаа			Чанарын менежер	Дулааны улиралд

#### 4.8 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 12. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө*

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7



№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	Ерөнхий үнэлгээ хийсэн төрийн захиргааны төв байгууллага	Тухайн жилийн БОМТ-ний Хэрэгжилтийн тайлан, дараа оны БОМТ-г боловсруулан хүргүүлж, батлуулна.	БОАЖ-ын сайдын 2019 оны 10 сарын 29 өдрийн А/618 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын үйлдвэрлэлийн хэсгийн бүтцийг хамарсан байна.	Жил бүрийн 12 сард багтаана	ҮА-ны зардал	Төслийн менежер БХА-ны дарга	БОАЖЯ-ны Хүрээлэн буй Орчин, Байгалийн Нөөцийн Удирдлагын газар
2	Нийслэлийн Байгаль Орчны Газар	БОМТ-ний биелэлтийн тайланг хүргүүлж, дүгнүүлнэ.		Жил бүрийн 11 сарын 01 дотор	ҮА-ны зардал	Төслийн менежер БХА-ны дарга	Нийслэлийн ЗДТГ
3	Баянгол дүүргийн 20-р хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэж, хамтран ажиллах			-	300,000		
	<b>Нийт</b>				<b>300,000</b>		

#### 4.9 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧИН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Монос Хүнс” ХК-ийн “Шингэн хүнсний үйлдвэр” төслийн 2021-2025 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖ-ын сайдын 2019 оны 10 сарын 29 өдрийн А/618 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулсан болно. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөнд 13 сая 593 мянган төгрөг зарцуулахаар тусгав.

Мөн компани нь МФС 2.0 үйлдвэрийн барилга, байгууламж болон хүчин чадлыг нэмэгдүүлж байгаатай холбоотойгоор Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тодотгол хийлгэх, мөн байгаль орчны аудит хийлгэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал
1	Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө	748,000
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	19,000,000
3	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	100,000
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,476,000
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,208,000
6	2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	300,000
	<b>Нийт зардал</b>	<b>22,832,000</b>

“Монос Хүнс” ХК-ийн “Шингэн хүнсний үйлдвэр”-ийн  
2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө



## ХАВСРАЛТ МАТЕРИАЛ

### Баримт бичгийн бүрдэл

№	Баримт бичгийн нэр	Тайлбар
Компанийн үйл ажиллагааны чиглэл		
1	Улсын бүртгэлийн гэрчилгээ	Монос Хүнс ХК - Улсы бүртгэлийн дугаар: - Регистрийн дугаар: 5568927 Үйл ажиллагааны чиглэл: Жүүс, ундаа, үрэл, цай зөөлөн капсултай бүтээгдэхүүн үйлдвэрлэл, гадаад худалдаа
Газартай холбоотой баримт бичиг		
2	Газар эзэмшин эрхийн зөвшөөрөл	Газар эзэмшигч: Монос Хүнс ХК
3	Газрын кадастр	Талбайн хэмжээ:
Үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрөл, дүгнэлт, гэрээ		
4	Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт	2024 оны 10 дугаар сарын 19 өдөр
5	Химийн бодисын зөвшөөрөл	2024 оны 12 сарын 31